



**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар A/11

Улаанбаатар хот

**Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийн хөгжил төлөвшил, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Эцэг эхийн зөвлөлийн дүрэм”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. “Эцэг эхийн зөвлөлийн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Зөвлөлийн дарга (Н.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.САЙНБАЯР

Газрын даргын 11-ны сарын  
11-ны өдрийн дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



## МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ-ЫН “ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Байгууллагын “Эцэг, эхийн зөвлөл” (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Зөвлөл нь байгууллагын албан хаагчдын гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийн хөгжил төлөвшил, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгуулсан хамт олны төлөөллөөс бүрдсэн зөвлөл байна.

### Хоёр. Бүтэц, зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хамт олны саналд тулгуурлан 5-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатай “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын даргын тушаалаар байгуулна.

2.2. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

2.3. Зөвлөлийн дарга нь үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зөвлөлийн нарийн бичгийн дарга нь улирал тутамд зөвлөлд үйл ажиллагаагаа тайлагнаж ажиллана.

2.4. Зөвлөлийн гишүүд нь “Хүүхэд хамгааллын бодлого”-той танилцаж гарын үсэг зурж зөвшөөрсөн байна.

2.5. Зөвлөл нь тухайн жилд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжилтийг ханган ажиллана.

2.6. Зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зөвлөлийн даргын саналаар хуралдуулж болно.

2.7. Гишүүдийн олонхи оролцсон үед зөвлөлийн хурлыг хүчинтэйд тооцох ба хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

2.8. Байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах үүрэгтэй. Энэ үүргийг хэрэгжүүлэх үүднээс зөвлөлийн дарга байгууллагатай хамтран ажиллагааны гэрээ байгуулж болно.

### Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Зөвлөл нь хүүхдийн эрх, хамгаалал, гэр бүлийн чиглэлээр холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа сэдвүүдээр сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулах, ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдийн судалгаанд тулгуурлан тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулна.

#### 3.1.1 Чиглэл

- а) Гэр бүлийн харилцаа, төлөвлөлтийн талаар сургалт зохион байгуулах;
- б) Өөрийн байгууллагын ажилтнуудад хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогийг таньж мэдэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмшүүлэх сургалт зохион байгуулах;

- с) Ажилтан, албан хаагчдыг хүүхэдтэйгээ хамт чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон гэр бүлд ээлтэй арга хэмжээ зохион байгуулах (аялал, өдөрлөг г.м) ;
- d) Олон улс, тив дэлхий, улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцож амжилт гаргасан хүүхдийг урамшуулах;
- е) Ажилтан, албан хаагчдад өөрийн хүүхдийн сурч буй орчинтой танилцах, багш удирдлагуудтай уулзах боломжийг бүрдүүлэх;
- f) Ажилтнуудад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах;
- g) Зөвлөлийн гишүүдийг гэр бүл, хүүхэд хамгааллын сургалтад үе шаттайгаар хамруулах;
- h) Эцэг, эхчүүдийн хүүхдийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс хүүхдийн эцэг, эхийн хуралд оролцох, эргүүл хийх боломжоор хангах;
- i) Зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулах;

3.2. Үйл ажиллагааны зардалд зарцуулах санхүүжилтийг байгууллагын хамт олны хуралд танилцуулна.

### **Дөрөв. Үйл ажиллагааны үр шимийг тайлагнах, хянах**

4.1. Зөвлөл нь тухайн жилд хийсэн ажлын тайланг жил бүр хамт олны хуралд танилцуулж, санал хүсэлтийг авч ажиллана. Ажлын үр дүнгээс хамаарч дараа жилийн үйл ажиллагаанд зориулах төсөв хөрөнгийг батлуулж болно. Байгууллага хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжилт хийнэ.

4.2. Зөвлөл нь жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлнэ.

Газрын даргын 14-дугаар тушаалын  
14-дүгээр хавсралт



МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ-ЫН  
ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн  
дарга:

Н.Отгонбаяр

Маркетинг, хамтын ажиллагааны албаны  
дарга

Гишүүд:

Ц.Лхамжав  
Р.Батгомбо  
М.Сувдгэрэл  
Ч.Чонцолдулам

Захиргаа, удирдлагын албаны дарга  
Жолооч  
Нярав  
Ахлах тогооч

Нарийн бичгийн  
дарга:

Ц.Энхмандах

Архив, бичиг хэрэг хариуцсан  
мэргэжилтэн